

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2026 оны 01 дүгээр сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



▶ ЭДИЙН ЗАСАГ 2025 ОНД

ДНБ-ий өсөлт

(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц

(2025 он)

7,005 сая \$

Инфляц

(2025 оны 12 дугаар сар)

7.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 12 дугаар сар)

-1,232 тэрбум ₮

Экспорт

(2025 он)

15.7 тэрбум \$

Импорт

(2025 он)

11.3 тэрбум \$

ГШХО

(2025 оны 3 дугаар улирал)

2.4 тэрбум \$

Зээлийн хүү

(2025 оны 12 дугаар сар)

17.2 хувь

Ажиллагчдын тоо

(2025 оны 4 дүгээр улирал)

1.38 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.3 хувь байна.

Бодит цалин

(2026 оны 1 сар)

2.4 сая

*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 4 дүгээр улирал)

116.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь

▶ ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2026.01

ДНБ-ий өсөлт

(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц

(2026 оны 1 дүгээр сар)

6,738 сая \$

Инфляц

(2026 оны 01 дүгээр сар)

7.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2026 оны 1 дүгээр сар)

-425.1 тэрбум ₮

Экспорт

(2026 оны 1 дүгээр сар)

1.7 тэрбум \$

Импорт

(2026 оны 1 дүгээр сар)

1.0 тэрбум \$

ГШХО

(2025 оны 3 дугаар улирал)

2.4 тэрбум \$

Зээлийн хүү

(2026 оны 1 дүгээр сар)

17.1 хувь

Ажиллагчдын тоо

(2025 оны 4 дүгээр улирал)

1.38 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.3 хувь байна.

Бодит цалин

(2026 оны 1 сар)

2.4 сая

*ХҮИ 2023=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 4 дүгээр улирал)

116.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 4 дүгээр улирал)


5.0 хувь



Эдийн засгийн өсөлт 2025 онд 6.8 хувь хүрч, сэргэлээ. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимжиж нийт өсөлтийг дэмжсэн байна. Хөдөө аж ахуй, боловсруулах, эрчим хүч, барилгын салбар өсөлтийг дэмжсэн бол худалдааны салбар агшиж өсөлтийг сааруулсан хэвээр байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(салбараар)

ДНБ	2024.IV	2025.IV
		5.1
Хөдөө аж ахуй	-28.7	33.2
Уул уурхай	10.8	10.6
Боловсруулах	-4.2	10.0
Цахилгаан, ус	4.8	9.4
Барилга	14.0	15.9
Худалдаа	11.9	-4.6
Тээвэр	16.4	4.8
Мэдээлэл, холбоо	17.4	7.2
Үйлчилгээний бусад	8.9	3.5
Цэвэр татвар	14.7	0.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2025 онд **6.8 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуй 33.2 хувиар тэлж, өсөлтийн 2.9 нэгж хувийг, уул уурхай 10.6 хувиар тэлж, өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 11.8 хувиар өсөж өсөлтийн 1.5 нэгж хувийг бүрдүүлэв.
- Үйлчилгээний салбар /худалдаанаас бусад үйлчилгээний салбарууд өссөн/ 2.7 хувиар өсөж, өсөлтийн 1.0 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 0.3 хувиар өсөж, өсөлтийг 0.04 нэгж хувиар дэмжив.

- Эдийн засгийн өсөлтийг хөдөө аж ахуйн салбар болон уул уурхайн салбарын өсөлт голлон дэмжсэн бол худалдааны салбар агшиж өсөлтийг сааруулла.
- Боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж, тээврийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж өсөлтөд эергээр нөлөөллөө.
- Хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурсны голлох нөлөөгөөр худалдааны салбар агшилттай байна.

- Уул уурхайн салбар 2025 онд 10.6 хувиар өслөө.
- Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл 2.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Нүүрс олборлолт 95.5 сая тонн болж, өмнөх оноос 4 хувиар, алт олборлолт 13 тоннд хүрч 4 хувиар тус тус өссөн бол газрын тосны олборлолт 3.8 сая баррел болж 10.6 хувиар буурав.

- Хөдөө аж ахуйн салбар 2025 онд 33.2 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал харьцангуй тогтуун байж, бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч (төл бойжилт 96.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдэн, том малын үеэ бус хоргодол өмнөх оны мөн үеэс 9 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр сүүлийн хоёр жил дараалан буурсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.



Өсөлтийг эрэлт талаас өрхийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал болон бараа, үйлчилгээний экспорт дэмжлээ.

ДНБ-ий өсөлт
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 6.6 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 3.3 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал, 4.0 нэгж хувийг цэвэр экспорт бүрдүүлсэн байна.
- Харин эргэлтийн хөрөнгийн бууралт өсөлтийг 6.9 нэгж хувиар, төрийн хэрэглээ 1.3 нэгж хувиар бууруулсан байна.

- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буурсан бол өрхийн хэрэглээний өсөлт хадгалагдаж, 9.2 хувиар өслөө.

- Үндсэн хөрөнгийн хуримтлал 9.0 хувиар өсөхөд орон сууцны бус барилга байгууламжийн нөөц бодитоор 19.6 хувиар, орон сууцны барилга 29.1 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн өмнөх онд бууралттай байсан биологийн өсөж үрждэг хөрөнгө өсөлттэй гарч хөрөнгийн хуримтлалыг дэмжлээ.


- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 6.2 хувиар өссөн бол бараа, үйлчилгээний импорт үргэлжлэн саарч 1.1 хувиар агшсанаар цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 1 дүгээр сард 55 хувиар өслөө. Уул уурхайн салбарт зэс, төмрийн хүдрийн олборлолтын биет хэмжээ болон үнэ өссөн нь голлон нөлөөлөв.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ


(гэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НҮҮРС ОЛБОРЛОЛТ

(сая тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлох бүтээгдэхүүнээр)

Салбар	Хэмжээ	Өмнөх оноос өөрчлөлт
Зэсийн баяжмал	195 мян.тонн	32.6%
Газрын тос	313 мян. баррель	-7.8%
Алт	0.6 тонн	-2.5%
Төмрийн хүдэр	0.5 сая.тонн	61.7%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2024=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2026 оны нэг сард 5.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 55 хувиар өслөө.
- Газрын тос болон бусад ашигт малтмалын үйлдвэрлэл буурсан ч металлын хүдэр олборлолт, нүүрсний олборлолт өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 68 хувиар өслөө.
- Боловсруулах салбарын үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2026 оны 1 дүгээр сард 4.6 хувиар өсөхөд ундаа үйлдвэрлэл болон хувцас, ээрэх нэхэх даавуун материал үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүний дотор 43 хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2026 оны 1 дүгээр сард 10.2 сая тонн болж, өмнөх оноос 56 хувиар өслөө.

*2024 оны байдлаар

- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2026 оны 1 дүгээр сард зэсийн баяжмалын үйлдвэрлэл 32.6 хувиар өсөж 195 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 0.5 сая тоннд хүрч, 61.7 хувиар өссөн байна.
- Харин алт олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс 2.5 хувиар, газрын тос олборлолт 7.8 хувиар буурсан байна.

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өссөн байна.

Үнэ өссөн:


- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 9.8 хувиар;
- Ундаа үйлдвэрлэл 19.4 хувиар;
- Металлын хүдэр олборлолт 62.1 хувиар;

Үнэ буурсан:


- Нүүрс олборлолт 23.7 хувиар;
- Газрын тос олборлолт 9.6 хувиар.




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны нэгдүгээр сард бодит дүнгээр 4.8 хувиар өсөв. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл, мах боловсруулах, консервлох, металл үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө.




- Боловсруулсан малын мах 2026 оны 1 дүгээр сард 1.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 60 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурахад хонь, адууны махны боловсруулалт буурсан нь нөлөөлсөн байна. Мөн боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) ӨМНӨХ ОНООС 30.7 хувиар буурлаа.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 16.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар буурсан байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурч боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) ӨМНӨХ ОНООС 12.5 хувиар буурлаа.




- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 43.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өслөө.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өсөж боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) ӨМНӨХ ОНООС 19.4 хувиар буурлаа.




- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2026 оны 1 дүгээр сард 72 тонн болж, өмнөх оны мөн үеэс 64 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдэж боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) ӨМНӨХ ОНООС 26.2 хувиар өндөр байна.




Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл, вакуум цонх болон хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, катодын зэсийн үйлдвэрлэл буурсан байна.



- Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 34 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 3.2 дахин өссөн байна.



- Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 582 тонн болж, өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар буураад байна.





- Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 6.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн байна.



- Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 1.8 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.



Нүүрсний тээвэр сэргэснээр төмөр замын ачаа тээвэр эхний 12 сард өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар өслөө. Инфляцын нөлөөгөөр засварласан дүнгээр зочид буудлын салбарын бодит орлого өссөн бол худалдаа, нийтийн хоолны салбарын бодит орлого буурсан үзүүлэлттэй байна.




ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2024.12	2025.12	ӨМНӨХ ОНООС:
Төмөр зам	45.9	49.9	8.7%
Уул уурхайн бүт.	32.9	36.7	11.5%
Агаар*	10.39	12.52	20.4%

	2024.IV	2025.IV	
Авто зам	87.8	96.5	9.9%
Уул уурхайн бүт.	60.0	64.4	7.3%

*мянган тонн
Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик улирлаар зарлагддаг.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны байдлаар нэрлэсэн дүнгээр 69.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 4.4 хувиар буурсан байна.

- 2025 оны байдлаар нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 17.5 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 11.9 хувиар өссөн байна.
- Үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 2.3 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 2.7 хувиар буурсан байна.


- Төмөр замаар 2025 оны байдлаар 49.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 20.4 хувийн өсөлттэй байна.
- Авто замаар 2025 онд 96.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 9.9 хувийн өсөлттэй байна.

- 2026 оны эхний сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 44.8 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.7 хувиар өссөн байна.



2026 оны 1 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 2.6 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 906.5 сая ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 1 дүгээр сард 1,749 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 71.8 хувиар өслөө.
- Нийт экспортын 96 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 640 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 36 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 726 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 175 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 167 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 134 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 50 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувиар өслөө.


ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2026 оны 1 дүгээр сард импорт 843 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар буурсан байна.
- Нийт импортын 25 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 20 хувийг тоног төхөөрөмж, 10 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 9 хувийг барилгын материал, 7 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Ачааны тээврийн хэрэгслийн импорт 61 хувиар, суудлын автомашины импорт 55 хувиар, тоног төхөөрөмжийн импорт 10 хувиар буурсан нь нийт импорт буурахад нөлөөллөө.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нефтийн бүтээгдэхүүний импорт 208 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 162 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10 хувиар буурсан байна.
- Суудлын автомашины импорт 62 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 55 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 74 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурлаа.
- Хүнсний импорт 85 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өслөө.



2026 оны 1 дүгээр сард уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 96 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



- Нүүрсний экспортын биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 10.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 73.5 хувиар өслөө.

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(мян. тонн)



- Зэсийн баямжлын экспортын биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 283 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 109.1 хувиар өслөө.

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 702 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өслөө.

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 284 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеийн түвшинд байна.




2026 оны 1 сард хөдөө аж ахуйн экспорт өмнөх оны мөн үеэс 59 хувиар нэмэгдлээ.


ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ ЭКСПОРТ (сая ам.доллар)




ХОНЬ, ЯМААНЫ МАХ (сая ам.доллар)




САМНАСАН НООЛУУР (сая ам.доллар)



АРЬС, ШИР (сая ам.доллар)




БОЛОВСРУУЛСАН МАХ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АДУУ, ҮХРИЙН МАХ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УГААСАН НООЛУУР (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2026 оны 1 дүгээр сарын дундаж үнэ 245 ам.долларт хүрч, өмнөх сараас 9 хувиар, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2026 оны 1 дүгээр сарын дундажаар 12,902 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 45 хувиар өссөн байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2026 оны 1 дүгээр дундаж үнэ 101 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн байна.

- Бrent газрын тосны 2026 оны 1 дүгээр сарын дундаж үнэ 68 ам.долларт хүрч өмнөх сараас 4 хувиар, өмнөх оны мөн үеэс 11 хувиар өслөө.

4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА


2026.01 сар



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2026 оны 1 сард 1.6 сая тонн нүүрс, 1.1 сая тонн төмрийн хүдэр арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ


(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2026 оны 1 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 62.5 сая тонн нүүрс арилжиж, 6.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 21.8 сая тонн нүүрс арилжиж, 1.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 1 сард 1.6 сая тонн нүүрс борлууллаа.


- 2026 оны 1 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 79 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 85 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 1 дугаар сард хэлцлийн доод үнэ 20 ам.доллар, дээд үнэ 115 ам.долларт хүрэв.

- 2026 оны 1 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 10.2 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 681 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2025 онд 5.9 сая тонн төмрийг арилжаалж, 380 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 1 сард 1.2 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 1 дугаар сарын дуудах дундаж үнэ 60 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 61 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 1 дугаар сард хэлцлийн доод үнэ 58 ам.доллар, дээд үнэ 88 ам.долларт хүрэв.



Төлбөрийн тэнцэл 2025 оны эцсийн байдлаар 1,034 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2026 оны 1 дүгээр сард өмнөх оноос 1.2 сая ам.доллороор өсөж, 6.7 тэрбум ам.долларт хүрлээ.



- Төлбөрийн тэнцэл 2025 оны 12 дугаар сарын байдлаар 1,034 сая ам.долларын ашигтай байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 1,701 сая ам.доллороор буурсан бол, санхүүгийн дансны ашиг 1,862 сая ам.доллороор их байна.

- Гадаад валютын улсын нөөц 2026 оны 1 дүгээр сарын эцэст 6,738 сая ам.доллар болж, өмнөх сараас 267 сая ам.доллар буурсан бол өмнөх оны мөн үеэс 1,228 сая ам.доллороор өслөө.

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 1 дүгээр сард өдөрт дунджаар 0.3 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,561 төгрөгт хүрлээ.

- Төв банк 2026 оны 1 дүгээр сард нийт 559 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Төв банк 2026 оны 1 дүгээр сард мөн үеэс 219 сая ам.доллороор бага буюу 559 сая ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн



Инфляц 2026 оны 1 дүгээр сард 7.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурсан байна. Инфляц өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурахад цахилгааны тарифын нөлөө арилсан нь голлон нөлөөлсөн байна. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.1 хувиар өслөө.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ

(хувь)



САРЫН ИНФЛЯЦ

(хувь)



СУУРЬ ИНФЛЯЦ

(хувь)



ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



- Инфляц 2026 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 7.5 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 1.9 нэгж хувь (25.5 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 5.6 нэгж хувь буюу 74.5 хувийг эзэлж байна.

- 2026 оны 1 дүгээр сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.1 хувиар өслөө.
- Сарын инфляц 1.1 хувь гарахад махны үнэ 8.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2026 оны 1 дүгээр сард суурь инфляц 6.0 хувь гарч, нийт инфляцын 3.7 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 2 сар дараалан буурлаа.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 13.2 хувийг бүрдүүлээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ 1,933 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурлаа. Хүнсний үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Хүнсний инфляц 2026 оны 1 дүгээр сард 12.6 хувь болж, нийт инфляцын 3.4 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц эрчимжихэд махны үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 5.6 хувь болж, нийт инфляцын 4.1 нэгж хувийг бүрдүүллээ.


ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 1 дүгээр сард дунджаар 3,561 төгрөг болж, өмнөх сараас 0.3 хувиар суларсан байна.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2026 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар өслөө.


ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ



Эх сурвалж: Drewry World Container Index

- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 2025 оны 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2026 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 1,933 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг бууруулж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Эх сурвалж: FAO

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард 123.9 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар тус тус буурсан байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээлд дээр сүүн бүтээгдэхүүн, мах, элсэн чихрийн үнэ өссөн бол ургамлын тос, үр тарианы үнэ өссөн байна.



Нэгдсэн төсвийн орлого 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 1,827.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар нэмэгдсэн бол зарлага 2,130.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурлаа.

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТАТВАРЫН ОРЛОГО


(татварын төрлүүдээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

УРСГАЛ ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 1.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 37.4 тэрбум төгрөг буюу 2.2 хувиар өссөн байна.
- Татварын орлого 2026 оны 1 дүгээр сард 1.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 135.8 тэрбум төгрөг буюу 9.3 хувиар өссөн бол татварын бус орлого 46.7 хувиар буурсан байна.
- Татварын бус орлогын бууралтад газрын тосны орлого 2026 оны 1 дүгээр сард 3.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 25 дахин буурсан нь нөлөөлсөн байна.

- Төсвийн орлогын өсөлтөд НӨАТ-ын орлого 469.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 173.3 тэрбум төгрөг буюу 58.5 хувиар, НД-ын орлого 382.6 тэрбум төгрөг хүрч, өмнөх оноос 54.2 тэрбум төгрөг буюу 16.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.
- Харин АМНАТ-ын орлого 2026 оны 1 дүгээр сард 148.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.7 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар буурсан байна.

- Нэгдсэн төсвийн зарлага 2026 оны 1 дүгээр сард 2.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 30.3 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар буурсан байна.
- Зарлагын бууралтад Хөрөнгийн зардал 257.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.3 тэрбум буюу 12.9 хувиар, хүүгийн төлбөр 129.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 87.8 тэрбум буюу 40.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

- Засгийн газрын 241-р тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг шинэчлэн, мөн 242-р тогтоолоор тэтгэврийн доод хэмжээг 80 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тогтоосноор тэтгэвэр, тэтгэмж 794.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар өссөн.
- Түүнчлэн Засгийн газрын 224-р тогтоолоор зарим салбарын албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 543.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар өссөн байна.



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 1 дүгээр сарын байдлаар цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийн зардлын өсөлтийн нөлөөгөөр 425 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

(Их наяд төгрөг)




ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(Их наяд төгрөг)



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг
Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Их наяд төгрөг)

	2024.IV	2025.IV	Өсөлт/бууралт
Засгийн газрын нийт өр	33.4	35.4	5.9%
ДНБ-д эзлэх хувь	42.4%	39.4%	
Засгийн газрын дотоод өр	0.4	0.7	75%
Засгийн газрын гадаад өр	30.3	32.1	5.9%
Үнэт цаас	8.7	9.0	3.4%
Зээл	21.6	23.1	6.9%
Засгийн газрын бусад өр	2.7	2.7	
ЗГ өрийн баталгаа	0.2	0.2	
Нийслэлийн үнэт цаас	2.6	2.5	(3.8)%

Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны эхний 1 дүгээр сард 425 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэврийг нэмэгдүүлсэн нь голлох нөлөө үзүүллээ.

- Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2026 оны эхний 1 дүгээр сарын байдлаар 303 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс төсвийн алдагдал 108 тэрбум төгрөгөөр буурсан байна.
- Төсвийн үндсэн тэнцэл 2026 оны 1 дүгээр сард 173 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу нийт тэнцлийн алдагдлаас 130 тэрбум төгрөгөөр бага байна. Энэ нь хүүгийн зардал төсвийн алдагдлыг нэмэгдүүлж байгааг харуулж байна.

- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 35.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өсөж, ДНБ-ий 39.4 хувьд хүрсэн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

- Засгийн газрын нийт өрийн 90 хувийг гадаад өр, үүний дотор 72 хувийг гадаад зээл, үлдсэн 28 хувийг гадаад үнэт цаас бүрдүүлж байна.
- Нийт өрийн бүтцэд гадаад өр давамгайлж байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл, олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хүүгийн түвшний өөрчлөлтөөс шууд хамаарах тул өрийн эрсдэл харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар өсөж, 46.8 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр сард 43.9 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 18.3 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Монголбанк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Монголбанк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 1 дүгээр сарын эцэст 46.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 10.5 нэгж хувь, гадаад валютын хадгаламж ба харилцах 0.5 нэгж хувийг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 31.6 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 26.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар өслөө.


- Банкнүүдэн зээлийн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр сарын эцэст 43.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй байна.

- Банкнүүдэн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 1 дүгээр сард 17.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өссөн бол өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурсан байна.
- Банкнүүдэн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 1 дүгээр сард 11.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өссөн бол өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурчээ.



Ажиллагчдын тоо 1 сая 384 мянгад хүрсэн ч өсөлтийн хурд саарч, ажилгүй иргэдийн өсөлтийн нөлөөгөөр ажиллах хүчний өсөлт нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 62.3 хувь болж өслөө.

АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ХҮЙСЭЭР (мянган хүн, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, САЛБАРААР (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДУНДАЖ ЦАЛИН, ГОЛЧ ЦАЛИН, БОДИТ ЦАЛИН (мянган төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 30 мянга буюу 2.2 хувиар нэмэгдэж 1 сая 384 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 195 мянгаар өндөр үзүүлэлт болов.
- 2025 оны 4 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 14 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 16 мянгаар тус тус өссөн байна.

- Ажиллагчдын тооны өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн нөлөөгөөр ажиллагчдын тоо 30 мянгаар нэмэгдсэн. Түүнчлэн уул уурхай, боловсруулах, барилгын салбарын ажиллагчид нэмэгдсэн нь нийт ажиллагчдын өсөлтийг дэмжсэн байна.
- Харин цахилгаан, ус, тээвэр, худалдааны салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.



- Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7.3 мянгаар өссөнөөр ажилгүйдлийн түвшин 5.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн байна.
- Харин ажиллах хүчний оролцооны түвшин ажиллагчид болон ажилгүй иргэдийн өсөлтийн нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсөж 62.3 хувьд хүрээд байна.

- Дундаж цалингийн хэмжээ 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 2 сая 905 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын голч цалин 2 сая 500 мянган төгрөг (дундаж цалингаас 405 мянган төгрөгөөр бага) байна. Энэ нь ажилчдын талаас илүү нь 2.5 сая төгрөгөөс бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Хэрэглээний үнийн индексээр засварлагдсан бодит цалин өмнөх 2 сая 417 мянган төгрөгт хүрлээ.

(Энд ХҮИ 2023=100)



Өрхийн бодит орлого 5 хувиар өслөө.



- Өрхийн бодит орлогын өсөлтийн эрчим өмнөх улирлаас сайжирч, 5.0 хувиар өсөв.
- Өрхийн орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 210.4 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 29.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Өрхийн орлого, зарлагын өсөлт тэнцвэржиж, иргэдийн хадгаламжийн өсөлт үргэлжлэн удааширсаар байна.

- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөлтгүй хэвээр байна.
- Нийт өрхийн 29.1 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж нэрлэсэн орлого 970 мянган төгрөгт хүрч өмнөх улирлаас 21.3 мянган төгрөгөөр, 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3.6 сая төгрөгт хүрч, өмнөх улирлынхаас 63 мянган төгрөгөөр тус тус өслөө.

- Хөдөөгийн өрхийн бодит орлогын өсөлт Улаанбаатар болон улсын дундажаас өндөр хэвээр хадгалагдаж байна.
- Үүнд 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 4 дүгээр улиралд 263.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 583 аар буюу 0.2 хувиар буурлаа.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО

(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 4 дугаар улиралд 263.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 583 аар буурлаа.
- Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.9 хувиар буурсан байна.
- Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

(ААН-ийн тоо, салбараар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 2.3 мянга, үйлчилгээний салбарт 2.3 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 18 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО

(мянга, ажиллагчдын тоогоор)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйл ажиллагаа явуулж буй 116.8 мянган ААН-ийн 101.4 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 102.9 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

(улирлаар, 2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа эвлэвгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 4 дүгээр улиралд 91.9 болж өмнөх оны мөн үеэс 12.8 нэгжээр муудлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 14.0 нэгжээр буурсан.
- Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 5.1 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 0.6 хувиар өслөө. Инфляцын түвшин 2026 оны 1 дүгээр сард 6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурсан байна.



- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 0.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурлаа.



- 2025 оны 12 дугаар сарын байдлаар экспорт 43.5 тэрбум ам.доллар, импорт 33.5 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 10 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10 хувиар өслөө.
- Импорт 2025 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14 хувиар өслөө.



- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2026 оны 1 дүгээр сард 6 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурсан байна.
- Жилийн инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.
- ОХУ-ын төв банкнаас 2 дугаар сарын 13-ны өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 15.5 хувьд хүргэх шийдвэр гаргасан.




- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2026 оны 1 дүгээр сард 49.4 болж, өмнөх сараас 1.3 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 12 дугаар сарын байдлаар 3.7 хувь болж, өмнөх сараас 3.3 нэгж хувиар өслөө.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, дотоодын эрэлт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2025 онд 5.0 хувиар өслөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ (хувь)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- БНХАУ-ын эдийн засаг 2025 онд 5.0 хувиар өслөө.
- 2025 оны 12 дүгээр сард экспорт 6.6 хувиар, импорт 5.7 хувиар тус тус өсөж өмнөх сараас чангарсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ (хувь)




Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарц 2025 оны 12 дугаар сард 5.2 хувиар өсөж, өмнөх сараас өсөлт саарлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 2025 оны 12 дугаар сард 0.9 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.


ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард 0.2 хувь гарч дефляцийн бүсээс рүү ойртлоо.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2026 оны 1 дүгээр сард -1.4 хувь гарч, үнийн уналт өмнөх сараас эрчимжлээ.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2026 оны 1 дүгээр 49.3 болж, агшилтыг илэрхийлсэн хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас буурч 50 доогуур болоод байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхижилтийг илэрхийлэх бөгөөд ААН-үндийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажиг эрлэлт, түүний эдийн нөөц зээг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ